



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Б.ХУРЦ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015. 04. 02 № 2/48

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8.9.2 Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Тагнуулын ерөнхий газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тагнуулын ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн газрын (хуучнаар) санхүүгийн тайланд бүртгэлтэй зарим төрийн өмчийн байрыг 7 харилцагч байгууллага, иргэдэд түрээсээр ашиглуулсан боловч 57,7 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг санхүүгийн тайланд авлагаар тусгаж баталгаажуулаагүй, нэхэмжилж аваагүй, Төрийн өмчийн хорооны 2007 оны 42 дугаар тогтоолоор баталсан төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусад өмчийн хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлэх төлбөрийн доод үнийг харгалзан түрээсийн гэрээ байгуулаагүй байна.

Төрийн өмчийн байрыг үнэ төлбөргүй ашиглуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, 28.5 дугаар зүйл, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 7, 8, 12-16 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам” 3.1.1 дэх заалтыг үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлж байна. Үүнд

1. Төрийн өмчийн байрыг цаашид түрээслүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэж, түрээслүүлэх бол Төрийн өмчийн хороонд зохих журмын дагуу асуудлыг тавьж, шийдвэрлүүлэх
2. Төрийн өмчийн хорооны 2007 оны 42 дугаар тогтоолоор баталсан төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусад өмчийн хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлэх төлбөрийн доод үнэ болон өмнөх гэрээг харгалзан төрийн өмчийн байрыг түрээслүүлсний төлбөрийг харилцагч тус бүрээр тооцоо нийлж, баталгаажуулан, няглан бодох бүртгэл, тайланд тусгаж, нөхөн төлүүлэх

3. Төрийн өмчийн байрыг түрээслүүлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 19-д заасны дагуу Төрийн өмчийн хороонд хүргүүлэх

Албан шаардлагын биелэлтийг 2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Тагнуулын ерөнхий газрын дарга, хурандаа Б.Хурц, Санхүү аж ахуйн хэлтсийн орлогч, санхүү төлөвлөлтийн тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, хошууч С.Жанхор нарт хариуцуулав.

АХЛАХ АУДИТОР



Ж.БАТСАЙХАН